

Хилийн чанадад оршин суугаа иргэд Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт захиалах ажиллагааг шуурхай болгох асуудлын хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 13-ны одор “Үндэсний энгийн гадаад паспорт олгох ажиллагааг хялбаршуулах тухай” Гадаад харилцааны яамны Торийн нарийн бичгийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Торийн нарийн бичгийн даргын хамтарсан а/07, а/02 тоот тушаал батлагдсантай холбогдуулан 2017 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс үндэсний энгийн гадаад паспортыг цахим хэлбэрээр захиалах журам руу шилжээд байна.

ЭСЯ хилийн чанадад оршин суугаа иргэдийн үндэсний энгийн гадаад паспортын захиалгыг хвлээн авч Оюуны Омч, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар /цаашид ООУБЕГ гэх/-т хүргүүлж, хэвлэгдэн гарсан гадаад паспортыг буцаан авч, баталгаажуулан иргэдэд хвлээлгэн огох вйл ажиллагаа нь ихээхэн хугацаа шаарддаг байсан ба дээрх журам хэрэгжиж эхэлснээр паспорт захиалгын хугацааг түргэсэх өндөр ач холбогдолтой болоод байгаа юм.

Иргэд үндэсний энгийн гадаад паспорт захиалахад шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэхэд дараах нэмэлт өөрчлөлт өрсөн болно. Үүнд:

Иргэд тус ЭСЯ-ны цахим хуудас дахь үндэсний энгийн гадаад паспорт захиалахад шаардагдах бичиг баримтын жагсаалтад дурдагсан материалыг бүрдүүлэхээс гадна өөрийн биеэр ЭСЯ-нд ирж цээж зурагаа авахуулах эсвэл өөрийн биеэр ирэх боломжгүй, паспорт захиалгын материалаа шуудангаар илгээж буй иргэд 3,5 x 4,5 см хэмжээтэй **цээж зурагаа**

цахим хэлбэрээр тус ЭСЯ-ны цахим шуудан болон фэйсбүүк хуудсаар дамжуулан ирүүлэх шаардлагатай болоод байна. Мон цээж зурагаа цахим хэлбэрээр ирүүлэхдээ паспорт захиалж буй хүний эцэг/эх-ийн нэр, нэр, регистрийн дугаарыг тодорхой тусгах хэрэгтэй.

Дээрх өөрчлөлтийн дүнд иргэдээс цахим хэлбэрээр ирүүлсэн цээж зургийг гадаад паспорт захиалж буй иргэний холбогдох мэдээллийн хамт цахим хэлбэрээр ООУБЕГ руу илгээснээр тус газарт хэвлэгдэж бэлэн болсон гадаад паспортыг ЭСЯ руу буцаан хүргүүлж ажиллахаар болсон ба паспорт захиалгын материалын эх хувийг ООУБЕГ-т хүргүүлэхийг хвлээх шаардлагагүй болсноороо давуу талтай юм.

Иймд иргэд та бүхэн үндэсний энгийн гадаад паспорт захиалахдаа тус ЭСЯ-нд цээж

Written by stockholm

Thursday, 16 March 2017 15:42 - Last Updated Thursday, 16 March 2017 15:45

---

зурагаа авахуулах болон оорийн биер ирж чадахгвй тохиолдолд шаардлага хангасан цээж зурагаа тус ЭСЯ руу цахимаар хвргvvлэх шаардлагатай болохыг анхаарна уу.

Жич: Тус ЭСЯ-нд иргэдийн цээж зургийг хэвлэхгвй богоод зовхон цахим хэлбэрээр хадгалж авах тул 3 ширхэг цээж зурагаа гадаад паспорт захиалгын материалдаа зайлшгвй хавсаргах шаардлагатайг анхаарна уу.

Дэлгэрэнгвй мэдээллийг [эндээс](#) харна уу.

Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа Элчин сайдын яам